



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

**Ардчилсан намын Үндсэн дүрмийн
нэмэлт, өөрчлөлт
бүртгүүлэх хүсэлтийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр, шүүгч С.Батдэлгэр, Б.Батцэрэн, Г.Банзрагч, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Х.Сонинбаяр, Д.Цолмон, Ц.Цогт, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсувд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

С.Эрдэнээс ирүүлсэн Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч Д.Мөнхтуяагийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

С.Эрдэнээс Улсын дээд шүүхэд хандаж “Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Намын их хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж заасны дагуу Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр хүргүүлж байна. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Үндэсний Бодлогын хорооны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хуралдааны 07 дугаар тогтоолоор баталсан болно. Холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэж өгнө үү” гэх хүсэлт гаргаж, хүсэлтдээ Намын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл, Ардчилсан намын Үндэсний Бодлогын хорооны ээлжит бус цахим хурлын 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоол, мөн хурлын тэмдэглэл, гишүүдийн цахим бүртгэл, Ардчилсан намын Үндсэн дүрэм, түүнд оруулсан өөрчлөлт, Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт зэргийг хавсарган ирүүлжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

С.Эрдэнийн гаргасан хүсэлтийг дараах үндэслэлээр хангахгүй орхиж, Ардчилсан намын Үндэсний Бодлогын хороо (цаашид ҮБХ гэх)-ны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хуралдааны 07 дугаар тогтоолоор батлагдсан Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

- Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлж, өргөдөл, хүсэлт гаргах эрх бүхий этгээдийн талаар:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг өргөдөл гаргах эрх бүхий этгээд гаргах”-аар заасан, тухайн тохиолдолд хүсэлт гаргагч С.Эрдэнийг Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, төлөөлж хүсэлт гаргах “эрх бүхий этгээд” гэж үзэх боломжгүй байна.

Тодруулбал, Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн шүүх хуралдааны 04 дүгээр тогтоолоор “... Ардчилсан нам /АН/-ыг төлөөлөх эрхтэй этгээд, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх асуудал маргаантай гэж үзэж Ц.Тувааныг намын даргын үүрэг гүйцэтгэгчээр цахим бүртгэлд бүртгэснийг хасч, ... Улсын дээд шүүхийн цахим бүртгэлд С.Эрдэнийг Ардчилсан намын даргаар бүртгүүлэх хүсэлтийг хангахаас татгалзаж ... , ... Ардчилсан намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар нам дотооддоо шийдвэрлэж, бүртгэл хийлгэхээр дахин хандах эрхтэй ба харин намыг төлөөлөх эрхтэй этгээдийн бүртгэл цахим мэдээлэлд тодорхой бус үлдсэн болохыг дурдаж ...” шийдвэрлэсэн, мөн шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “... С.Эрдэнэ, Ц.Туваан нарыг намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд болохыг тогтоосон 2021 оны 01 дүгээр сарын 15, 16-ны өдрийн Үндсэн дүрмийн хорооны хуралдааны тогтоолуудыг хүчин төгөлдөр шийдвэр гэж үзэх үндэслэлгүй, улмаар Намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар нам дотооддоо шийдвэрлэх талаарх Улсын дээд шүүхийн 04 дүгээр тогтоолд заасан зөрчил арилаагүй” гэсэн дүгнэлт хийж, “Улсын дээд шүүхийн цахим бүртгэлд Ардчилсан намын даргаар бүртгэгдсэн бүртгэлийг сэргээлгэх”-ээр гаргасан С.Эрдэнийн хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн, түүнчлэн, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Улсын дээд шүүхийн 2021 оны дээр дурдсан 04, 09 дүгээр тогтоолууд хүчин төгөлдөр, түүнд дүгнэгдсэн нөхцөл байдлууд арилаагүй гэж үзэж, намын даргаар О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг бүртгүүлэхээр ирүүлсэн хүсэлт, түүнчлэн “Улсын дээд шүүхийн цахим сан дахь С.Эрдэнийн бүртгэлийг сэргээх тухай” гаргасан хүсэлтүүдийг тус тус хангахгүй орхиж шийдвэрлэсэн, эдгээр тогтоолууд хүчин төгөлдөр байна.

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.17.1, 5.17.4.1-д тус тус зааснаар “Намын дарга нь Намын тэргүүн бөгөөд Ардчилсан намыг төлөөлөх эрх бүхий этгээд” байх тул тус намын дарга нь улсын бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэлд өөрчлөлт орсныг бүртгүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй, харин энэ тохиолдолд, Ардчилсан намын дарга буюу итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд нь хэн болох талаар намын доторх маргаан эцэслэгдэж улсын бүртгэлд бүртгэгдээгүй, уг асуудлаарх шүүхийн дээрх тогтоолуудад заасан үндэслэл арилаагүй байна.

Иймд, “Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх”-ээр ирүүлсэн С.Эрдэнийн өргөдөл, хүсэлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан шаардлагыг хангахгүй байна гэж үзэх үндэслэлтэй.

- Үндэсний Бодлогын хорооны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хуралдааны хүчин төгөлдөр байдлын талаар:

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.13.2-т “ҮБХ нь Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол УИХ-ын сонгуулийн тойргийн мандатын тоог 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тооны гишүүдтэй байна ...”, 5.13.9-д “ҮБХ нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана”, 5.13.10-т “ҮБХ-ны ээлжит хурлыг Намын дарга эсхүл УТЗ-өөс зарлана. ҮБХ-ны тухайн хурлаас дараагийн хурлын товыг тогтоож болно ...”, 5.13.13.1-д ҮБХ-г шаардан хуралдуулах журмыг зохицуулахдаа “Намын дарга эсхүл УТЗ нь ҮБХ-ны

1/3-ээс доошгүй гишүүдийн шаардлагаар 14 хоногоос хэтрүүлэлгүйгээр зарлан хуралдуулах үүрэгтэй”, 5.13.13.2-т “шаардлагад Үндсэн дүрэм бусад журамд нийцсэн хурлын тов, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл тодорхой тусгагдсан байх бөгөөд ээлжит бус хурлыг ҮБХ-ны гишүүд гарын үсгээ зурж баталгаажуулсан байна” гэж тус тус заажээ.

Хүсэлтэд хавсаргаж ирүүлсэн хурлын тэмдэглэлд “... Ардчилсан намын ҮБХ-ны ээлжит бус цахим хуралдаанаар ҮБХ-ны 301 гишүүнээс хуралдаанд 164 гишүүн оролцож, 54.4 хувийн ирцтэй байх бөгөөд Үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг нийт хуралдаанд оролцогчдын 97 хувийн саналаар дэмжигдсэн” гэж тэмдэглэгдсэн боловч, шүүхэд ирүүлсэн “хуралд оролцсон гишүүдийн цахим бүртгэл”-д 159 хүн оролцсон гэж тэмдэглэсэн, түүнчлэн ҮБХ-ны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хуралдааныг хэн, хэзээ, ямар шийдвэрээр зарласан, хэлэлцэх асуудал, хурлын товыг хэрхэн тогтоосон талаар баримт ирүүлээгүй байх тул ҮБХ-ны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хурал нь Ардчилсан намын Үндсэн дүрэмд заасан журмын дагуу зохион байгуулагдсан эсэх, хүчин төгөлдөр эсэх талаар шүүх дүгнэлт хийх боломжгүй байна.

- ҮБХ-ны ээлжит бус цахим хуралдаанаар Ардчилсан намын Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийн талаар:

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 4.4-т “Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг таслах эрхтэй нийт гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ”, 5.13.12.15-д “төрийн сонгуулийн хууль өөрчлөгдсөн тохиолдолд намын Их хурал зарлан хуралдуулах цаг хугацааны боломжгүй үед ҮБХ-ны нийт гишүүдийн 2/3-ын саналаар намын Үндсэн дүрэмд зөвхөн уг асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах /эрхийг ҮБХ-нд олгосон/”, 9.1.1-д “намын ... Үндсэн дүрэм ...-д нэмэлт өөрчлөлт оруулах ... асуудлыг ҮБХ-ны Үзэл баримтлал, Үндсэн дүрмийн Зөвлөлийн саналд үндэслэн ҮБХ-ноос намын Их хуралд өргөн барина” гэж тус тус заажээ.

Ардчилсан намын ҮБХ-ны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хурлаар Ардчилсан намын Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэхдээ Ардчилсан намын Үндсэн дүрмийн дээрх заалтууд хэрхэн хэрэгжсэн талаарх баримтыг шүүхэд ирүүлээгүй байх тул Ардчилсан намын Үндсэн дүрмийн 3.10.1.1, 3.10.1.2, 3.10.2.1, 3.10.2.2, 5.13.1, 5.17.6.1 дэх заалтуудыг өөрчлөн найруулсан, 3.10.1.2.2, 3.10.1.3, 3.10.3, 5.10.11.6, 5.15.11, 5.15.12, 5.15.13 дахь заалтуудыг хүчингүй болгосон, Үндсэн дүрэмд 5.13.12.27.16, 5.13.12.27.17 гэсэн заалтуудыг нэмсэн нь ҮБХ-ны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хурлын бүрэн эрхэд хамаарч байгаа эсэх үндэслэл тодорхойгүй байна.

Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1-д “намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах /асуудлыг зөвхөн намын Их Хурлаар шийдвэрлэнэ/”, 13.4-т “намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж тус тус заасан, тухайн тохиолдолд, Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар болон уг асуудлаар шийдвэр гаргах ҮБХ-ны эрх хэмжээг Ардчилсан намын Үндсэн дүрэмд дээрх байдлаар тусгайлан зохицуулсан байх тул хүсэлтэд хавсарган ирүүлсэн бичгийн баримтын хүрээнд, ҮБХ-ны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хурлаар Ардчилсан намын Үндсэн дүрэмд нэмэлт

өөрчлөлт оруулсан нь “Үндсэн дүрмээр ҮБХ-нд олгосон эрх хэмжээний хүрээнд гаргасан шийдвэр” гэж шүүх дүгнэх боломжгүй.

Эдгээр үндэслэлээр, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д “улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу /тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах/”-аар заасны дагуу Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзах нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

Ардчилсан нам нь Улсын дээд шүүхийн 2021 оны 04, 09 дүгээр тогтоол, нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолын үндэслэлд заасан зөрчлөө арилгаж, Улс төрийн намын тухай хууль болон Үндсэн дүрэмдээ нийцүүлэн шийдвэр гаргах замаар намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодруулж, Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаа эрх бүхий этгээд нь зохих журмын дагуу шийдвэрлэх, ийнхүү шийдвэрлэсэн талаарх баримтаа бүрэн бүрдүүлсний дараа холбогдох хүсэлтээ Улсын дээд шүүхэд дахин гаргах эрхтэй болохыг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ардчилсан намын Үндэсний Бодлогын хорооны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус цахим хуралдааны 07 дугаар тогтоолоор оруулсан Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.

2. Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.МӨНХТУЯА